

ХОЁРДУГААР САР ЯАГААД БОГИНО БАЙДАГ ВЭ?

(Түүхэн тэмдэглэл)

Д.Дашдулам

Түүхийн шинжлэх ухааны хавсарга ухаануудын нэг болох хронологийн үүсэл, хөгжлийн асуудал эрдэмтэд, судлаачдын анхаарлыг зүй ёсоор татсаар ирсэн юм.

Chronology нь он тоолол, цаг хугацааг хэмжих тухай шинжлэх ухаан юм. Цаг хугацааг тооцох шаардлага эрт үеэс ахуй амьдрал, аж ахуйгаа эрхлэн хөтлөх зайлшгүй шаардлагын улмаас үүсэн гарсан билээ. Иймээс улс орон, ард түмнүүд түүхийн үеүдэд янз бүрийн цаг хугацааг он тоолол болгон хэрэглэж ирсэн уламжлалтай юм. Гэхдээ тэд ихэвчлэн цаг хугацааг тооцохдоо одон орны үзэгдэл дээр тулгуурлаж байсан бөгөөд түүхэн онцгой үйл явдал, шашин болон шинэчлэлийн зүйлүүдтэй нөхцөлдөн өөрчилдөг байжээ.

Бид бүхний эдүгээгийн хэрэглэж байгаа цаг тооны бичгийн үндэс болсон Юлианы он тоолол хэрхэн үүссэн талаар товч хэдэн зүйлийг хэлье гэж бодож байна.

Юлианы он тоолол нэвтрэхээс өмнө эртний Ромд он тооллын цөөнгүй арга хэлбэр, тогтолцоо солигджээ. МЭӨ VIII зуунд тэнд “Ромулын жил” ноёрхож байлаа. Хавар эхэлж өвлийн улирлын эхэн хавьд дуусдаг байсан тэр жил нь урт богино янз бүрийн хугацаагаар үргэлжлэх 10 сараас бүтдэг ба нийт 304 өдөртэй байжээ. Харин үлдсэн өдрүүдийг нь аливаа нэг сард хамааруулдаггүй байсан аж. “Децембер” хэмээн нэрлэх сүүлийн сар дуусахад ромчуудын хувьд нэргүй, тодорхой бус үе эхэлж, шинэ жилийн эхний өдөр буюу “мартуус” сарын эхний өдрийг тэсвэртэй нь аргагүй хүлээнэ.

Манай эрний өмнөх VI зуунд он тооллын шинэчлэл хийгдэж, цаг тооны бичигт эртний Ромын бурхан Янусын нэрээр нэрлэгдсэн “януарис” ба “февруарис” саруудыг нэмжээ. “Февруарис” гэдэг нэр нь Ромд баримталдаг байсан “фералий” буюу үрэгдэгсдийг эргэн дурсах долоо хоног, аль эсвэл газрын гүний бурхан Февруусийн нэртэй холбоотой хэмээн үздэг. Сүсэг бишрэлтэй ромчууд сондгой тоог азтайд, харин тэгш тоог азгүйд тооцдог байв. Ингээд арван хоёр сарын дөрөв нь 31, долоо нь 29 хоногтой болж, харин февруарис сар ганцаараа 28 хоногтой үлджээ. Чухам яагаад заавал февруарис сар 28 хоногтой болсон талаар таамаглахаас өөр аргагүй. Магадгүй, жилийн эцсийн сар байсан болоод тэр байж ч мэднэ...

Энэхүү тооллын дагуу жилийн үргэлжлэх хугацаа одон орны тооллынхоос 10.242 өдрөөр богино байсан тул жилийн эхлэх хугацааг улирлын эхэн үетэй тааруулахын тулд санваартнууд фебруарис сарын эцэс, мартиус сарын эхний хооронд нэмэлт өдрүүдийг “оруулж” өгдөг байв.

Энэ дураараа авирлах явдалд Юлий Цезарь манай эриний өмнөх 46 онд цэг тавьж, цаг тооллын шинэчлэл хийсэн бөгөөд үүний дагуу жилийн үргэлжлэх хугацаа 365 хоногтой тэнцэх болж, дөрөв дэх жил бүрийг “өндөр жил”-ээр өргөмжилсөн билээ. Үүний зэрэгцээ жилийн эхлэлийг януарис сарын эхний өдөр буюу бидний хэлж заншсанаар нэгдүгээр сарын нэгэн болгон өөрчилсөн байна. Эхэн үедээ юлианы тооллоор 31 хоногтой сарууд 30 хоногтой сартай ээлжилдэг байсан ба хоёрдугаар сар хүртэл 30 хоногтой байв. Гэвч ийм зохицолыг хадгалахад нэг хоног дутаж байв. Иймд зуны бүх сарыг богино буюу 30 хоногтой болгохоор тогтжээ. Үүнд талархсаны илэрхийлэл болгон Ромын сенат нь Цезарийн төрсөн “квинтилис” сарыг түүний нэрээр буюу “юлиус” хэмээн нэрлэжээ. Дээр дурьдсанчлан, ромчууд сондгой тоонд таагүй ханддаг байсан тул энэхүү онцгой хүндтэй сар нь 30 хоногтой байх нь тохиромжгүй хэмээн үзэж юлиус сарыг 31 хоногтой болгон фебруарис сараас нэг хоногийг хасан 29 хоногтой болгосон байна.

Цаг хугацаа өнгөрч, Ромын эзэн хааны суудалд Август суух үед санваартнууд “өндөр жил” байлгахыг эсэргүүцэн цаг тоолол хөтлөх журмыг хангалттай будлиантуулж амжжээ. Август алдааг залруулан манай эрний өмнөх 8 онд юлианы цаг тооллыг бүрэн хэмжээгээр нь мөрдөж эхэлжээ. Эзэн хааны шийдэмгийн зан, эх орны өмнө байгуулсан гавъяаг үнэлэн, Ромын сенат “секстилис” нэртэй сарыг өөрчлөн “август” хэмээн нэрлэсэн байна. Мөн дээр дурьдсан шалтгааны улмаас түүнийг 31 хоногтой болгов. Гэтэл бас л авцалдаагүй зүйл буй болж, 7, 8, 9 гэсэн гурван сар дараалан 31 хоногтой болсон тул дахин хасах танах ажил эхэлжээ. Есдүгээр сарын нэг өдрийг 10 дугаар сард шилжүүлж, арваннэгдүгээр сарын нэг өдрийг арванхоёрдугаар сард шилжүүлж үзэв. Харин август буюу наймдугаар сар хэрхэн 31 хоногтой болсоныг авч үзвэл мөн л фебруарис сараас нэг хоногийг “зээлсэн” байв.

Түүнээс хойш хоёр мянга гаруй жил өнгөрсөн ч Ромын сенатын “шагналын” журмаар буй болгосон “жигд” бус сарууд бидний цагийн тоололд ноёлсоор л байна. Үүнийг дахин залруулж болох болов уу? Зарчмын хувьд мэдээж болно. Гэвч бид

бүхний амьдралын хэв шинж, уламжлал, зан заншил, баяр наадам зэрэг нь бүгд одоогийн цаг тоололтой холбоотой тул тун ч бэрх ажил болох нь ойлгомжтой юм.